



ЦЭРГИЙН ДҮРЭМТ ХУВЦАС ӨМСӨХ ДҮРЭМ

Цуврал №1 Хээрийн дүрэмт хувцсыг өмсөж хэрэглэх

2026 он



Хээрийн дүрэмт хувцсыг өмсөж хэрэглэх

Алба хаагч хээрийн дадлага, сургуульд оролцох, байлдааны жижүүрлэлт, харуул, хоногийн манааны болон тусгай үүрэг гүйцэтгэх, анги, байгууллагыг шалгах, шалган туслах ажлаар явах, бэлтгэл үүрэгтэн цэргийн дайчилгааны цугларалт, сургуульд оролцох үед өмсөж хэрэглэнэ.

Цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хаагч цэргийн сургалт бэлтгэл, өдөр тутмын үйл ажиллагаанд хээрийн дүрэмт хувцсыг өмсөнө.

Хээрийн дүрэмт хувцсыг өмсөж, хэрэглэх цаг улирлаас хамааран дулааны, хүйтний улирлын болон сэрүүний үеийн гэж ангилна.





Хээрийн дүрэмт хувцсыг дулааны улиралд өмсөж хэрэглэх



Хээрийн китель, өмдийг хээрийн малгай, футболк, хээрийн дотуур цамц, ноосон цамц, тактикийн бүс, хээрийн гуталтай өмсөж, чимэг хэрэглэлийг зүүж хэрэглэнэ. Алба хаагч өмдний шуумгийг гутлын түрийний гадуур хийж өмсөнө.

Дотоодын цэргийн байгууллагын алба хаагчид штаб, анги, салбарын дотоодын харуул, жижүүр, УОЧО-ын хамгаалалт, гудамж талбайд эргүүлийн үүрэг гүйцэтгэх үед өмсөж хэрэглэнэ.



Хээрийн дүрэмт хувцсыг дулааны улиралд өмсөж хэрэглэх



Зүүн ханцуйнд Төрийн далбаа, байгууллагын ялгах тэмдэг, баруун ханцуйнд цусны бүлэг, анги, байгууллагын ялгах тэмдэг, энгэрийн баруун талд нэр, зүүн талд байгууллагын нэр зангуун наалттай байна.

Захирагч (дарга)-ийн шийдвэрээр дулааны улиралд берет малгайтай хослуулан өмсөж болно.



Хээрийн дүрэмт хувцсыг дулааны улиралд өмсөж хэрэглэх



Захтай футболкийг хээрийн малгай, хээрийн өмд, хээрийн гуталтай өмсөж, чимэг хэрэглэлийг зүүж хэрэглэнэ.

Хээрийн мөрдэс, зүүн ханцуйнд байгууллагын, баруун ханцуйнд анги байгууллагын ялгах тэмдэг, энгэрийн баруун талд зангуун дэвсгэр дээр нэрийн тэмдэг зүүнэ.

Захтай футболкийг хээрийн дүрэмт хувцсан дээр зөвхөн дулааны улиралд өмсөж, хэрэглэнэ.



Хээрийн дүрэмт хувцсыг дулааны улиралд өмсөж хэрэглэх



Хээрийн дотуур цамцыг хээрийн зуны кительний дотор өмсөх ба зөвхөн тусгай зориулалтын хамгаалах хэрэгсэл өмссөн үед дангаар өмсөж болно.

Баруун ханцуйнд анги, байгууллагын ялгах тэмдэг, зүүн ханцуйнд байгууллагын ялгах тэмдэг зангуун наалттай байна.



Хээрийн дүрэмт хувцсыг сэрүүний үед өмсөж хэрэглэх



Хээрийн хүрэм, өмдийг хээрийн малгай, берэт малгай, хээрийн китель, хээрийн дулаан цамц, тактикийн бүс, хээрийн гутал, савхи (тактик)-н бээлийтэй өмсөж, чимэг хэрэглэлийг зүүж хэрэглэнэ. Өмдний шуумгийг гутлын түрийний гадуур тавьж өмсөнө.

Зүүн ханцуйнд Төрийн далбаа, байгууллагын ялгах тэмдэг, баруун ханцуйнд цусны бүлэг, анги, байгууллагын ялгах тэмдэг, энгэрийн баруун талд нэр, зүүн талд байгууллагын нэр зангуун наалттай байна.

Захирагч (дарга)-ийн шийдвэрээр ноосон малгай, хоолойвчтой хослуулан өмсөж болно.



Хээрийн дүрэмт хувцсыг сэрүүний үед өмсөж хэрэглэх



Хээрийн дулаан цамцыг хээрийн малгай, өмд, гуталтайгаар өвлийн хээрийн хүрэм, китель дотор өмсөж, хэрэглэх бөгөөд сэрүүний болон хүйтний улиралд өмсөж хэрэглэнэ.

Захирагч (дарга)-д илтгэл өгөх болон нэгдсэн ажиллагаанаас бусад үед дангаар нь өмсөж болох ба чимэг хэрэглэлийг зүүж хэрэглэнэ.

Хээрийн мөрдэс, энгэрийн баруун талд цэргийн алба хаагч нэр, зүүн талд байгууллагын нэр зангуун наалттай байна.



Хээрийн дүрэмт хувцасыг хүйтний улиралд өмсөж хэрэглэх



Өвлийн хээрийн хүрэм, өмдийг ноосон малгай (хоолойвч), хээрийн китель, хээрийн дулаан цамц, тактикийн бүс, хээрийн гутал, савхи (тактик)-н бээлийтэй өмсөж, чимэг хэрэглэлийг зүүж хэрэглэнэ.

Зүүн ханцуйнд Төрийн далбаа, байгууллагын ялгах тэмдэг, баруун ханцуйнд цусны бүлэг, анги, байгууллагын ялгах тэмдэг, энгэрийн баруун талд нэр, зүүн талд байгууллагын нэр зангуун наалттай байна.

Ноосон цамцыг хээрийн китель өмссөн үед хээрийн мөрдэстэй өмсөнө. Албаны өрөөнд дангаар нь хээрийн өмдтэй хослуулан өмсөж болно.



Хугацаат цэргийн алба хаагч хээрийн дүрэмт хувцсыг дулааны улиралд өмсөж хэрэглэх



Хээрийн китель, өмдийг хээрийн малгай (шар өнгийн хатгамал соёмботой), тактикийн бүс, өмдний тэлээ, хээрийн гуталтай өмсөж, чимэг хэрэглэлийг зүүж хэрэглэнэ.

Зүүн ханцуйнд “Mongolia” тэмдэг, байгууллагын ялгах тэмдэг, баруун ханцуйнд, анги, байгууллагын ялгах тэмдэг, энгэрийн баруун талд нэр, зүүн талд байгууллагын нэр байна.

Хугацаат цэргийн алба хаагчид өмдний шуумгийг гутлын түрийг өмдний дотор хийж өмсөнө.



Хугацаат цэргийн алба хаагч хээрийн дүрэмт хувцсыг хүйтний улиралд өмсөж хэрэглэх



Өвлийн хээрийн хүрэм, өмдийг цегейк малгай, хээрийн китель, ноосон цамц, тактикийн бүс, өмдний тэлээ, бээлий, хээрийн гуталтай өмсөж, чимэг хэрэглэлийг зүүж хэрэглэнэ.

Ноосон малгай (хоолойвч)-г цаг агаарын нөхцөл байдалд тохируулан захирагч, даргын шийдвэрээр өмсөнө.

Зүүн ханцуйнд “Mongolia” тэмдэг, байгууллагын ялгах тэмдэг, баруун ханцуйнд, анги, байгууллагын ялгах тэмдэг, энгэрийн баруун талд нэр, зүүн талд байгууллагын нэр байна.



Чимэг, хэрэглэл зүүж хэрэглэх

“Улс, байгууллагын ялгах нэр” тэмдэг (хатгамал)

ДОТООДЫН ЦЭРЭГ

ДЦШ

Хээрийн хувцасны зүүн энгэрт, халаасны дээд ирмэгт тэмдгийг оёж (нааж) тогтооно.

Дотоодын цэргийн штаб – ДЦШ

Анги, тусгай салбар – Дотоодын цэрэг гэсэн тэмдэглэгээтэй байна.

Нэрийн тэмдэг (хатгамал)

Т.ЭРХЭМБАЯР

Нэрийн тэмдгийн доод үзүүрийг хээрийн хувцасны баруун энгэрт голлуулан хадна.

Цусны бүлэг тодорхойлсон тэмдэг (хатгамал)

О(+)

Тэмдгийн доод ирмэгийг анги байгууллагын ялгах тэмдгийн дээд ирмэгт тулган хээрийн хувцасны баруун ханцуйнд оёж (нааж) тогтооно.

Төрийн далбаа (хатгамал)



Хээрийн хувцасны зүүн ханцуйд халаасны дээд ирмэгийн оёдолд тулган байгууллагын ялгах тэмдгийн дээр хадаж (нааж) тогтооно.



Чимэг, хэрэглэл зүүж хэрэглэх

Анги, байгууллагын ялгах тэмдэг (хатгамал):



Хээрийн китель, хээрийн хүрэм, өвлийн хээрийн хүрэмний баруун ханцуйны мөрний залгаа оёдлоос доош 120 мм зайд тогтооно.

Байгууллагын ялгах тэмдэг (хатгамал)



Хээрийн китель, хээрийн хүрэм, өвлийн хээрийн хүрэмний зүүн ханцуйны мөрний залгаа оёдлоос доош 120 мм зайд тогтооно.

Мэргэжлийн зэргийн тэмдэг (хатгамал)



Хээрийн кителийн энгэрийн зүүн халаасыг голлуулж зүүнэ.



Хориглох нь:

✓ Цэргийн дүрэмт хувцас, хэрэглэлийг урлаг, уран сайхны кино, хошин хөтөлбөр зэрэг арга хэмжээнд зөвшөөрөлгүй ашиглах, ашиглуулах;

✓ Цэргийн дүрэмт хувцас, хэрэглэлийг бусдад шилжүүлэх, бэлэглэх, хэрэглүүлэх, түрээслэх, худалдах, өнгө, загвар, стандартыг өөрчлөх, өөр хооронд нь буюу энгийн хувцастай хольж өмсөх;

✓ Гадаад улсын цэргийн дүрэмт хувцас өмсөж, хэрэглэх;

✓ Үс, хумсыг хурц, тод өнгөөр будах, үсийг дух, нүд, шанаа, хацар, мөр дагуу унжуулах, этгээд маягаар засуулах;

✓ Хэт том, хурц өнгөтэй гинж, ээмэг, бөгж, зүүлт, бугуйвч зэрэг гоёл чимэглэл, шашны зан үйлтэй холбоотой эд зүйл зүүж хэрэглэх;

Эмэгтэй алба хаагч үсээ мөрнөөс дээш шууж, хар өнгийн боолтоор бооно.



АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА